

БҮТЭЭМЖ ТООЦОХ АРГАЧЛАЛ

АГУУЛГА

1. Оршил

2. Бүтээмжийн тухай ерөнхий ойлголт

3. Бүтээмжийн төрлүүд, түүнийг тооцох аргууд

3.1 Нийт бүтээмж

3.2 Үндсэн хүчин зүйлсийн бүтээмж

3.3 Тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмж

3.3.1 Хөдөлмөрийн бүтээмж

3.3.2 Капиталын бүтээмж

3.3.3 Түүхий эд, үндсэн материалын бүтээмж

3.3.4 Эрчим хүчний бүтээмж

4. Хавсралтууд:

Хүснэгт – 1 – Мал аж ахуйн салбарын бүтээмжийн тооцоо

Хүснэгт – 2 – Боловсруулах салбарын бүтээмжийн тооцоо

Хүснэгт – 3 – Дотоод худалдааны салбарын бүтээмжийн тооцоо

Бүтээмж тооцох аргачлал

1. Оршил

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд бүтээмжийн өсөлт ихээхэн чухал байдаг. Бүтээмж гэдэг нь нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулж, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай зарцуулж зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосноор бүтээмж өндөр байх ба бүтээмжийн энэхүү өндөр түвшин нь улс орон, цаашилбал аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварыг илүү өндөр, тогтвортой түвшинд хүргэх бололцоог бүрдүүлэн, улмаар нийгмийн баялгийг нэмэгдүүлж, хүн амын амьжиргааны түвшин, орлогыг өсгөдөг. Орлого өсөхийн хэрээр хадгаламж нэмэгдэж үүнийг даган хөрөнгө оруулалт өссөнөөр эргээд бүтээмж өсч, энэхүү циклийн үр дүнд улс орон хөгжлийн илүү өндөр түвшинд хүрдэг.

Дэлхийн хүн ам эрчимтэй өсч, түүнийг дагаад хүн амын хэрэглээ улам бүр нэмэгдэж, энэхүү нэмэгдэж байгаа хэрэглээг хангах зорилгоор байгалийн дахин нөхөн сэргэдэггүй нөөцийг ихээхэн ашиглах болсон өнөө үед бүтээмж гэдэг ойлголт ихээхэн чухал үзүүлэлт болж, Олон улсын байгууллагууд (тухайлбал Азийн бүтээмжийн байгууллага) улс орнуудын бүтээмжийг тооцож бодлого боловсруулагчид, судлаачид, бизнес эрхлэгчдийн хүртээл болгож байна. Ингэж улс орнуудын бүтээмжийг тооцож зэрэгцүүлснээр өөрийн улсын үйлдвэрлэл хэр үр ашигтай байгааг бусад оронтой харьцуулан судлах, цаашид ямар бодлого боловсруулахаа шийдэх, аж ахуйн нэгжийн хувьд өөрийн бизнесийг хэр зэрэг үр ашигтай эрхэлж чадаж байгаагаа цэгнэж цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

Манай улсын хувьд бүтээмжийг улс орны нийт эдийн засгийн түвшинд, салбаруудын түвшинд, аж ахуйн нэгж, байгууллагуудын түвшинд тооцсоноор бодлого боловсруулагчид, судлаачид, бизнес эрхлэгчдэд төдийгүй олон улсын түвшинтэй өөрийн орныг зэрэгцүүлэх өргөн боломж нээгдэх юм.

2. Бүтээмжийн тухай ерөнхий ойлголт

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байгааг тодорхойлдог үзүүлэлт юм.

Бүтээмж бол хязгаарлагдмал нөөцөөр нийгмийн байнга өсөн нэмэгдэх хэрэгцээг хэрхэн хангах вэ гэсэн эдийн засгийн үндсэн асуудлыг ямар түвшинд, хэр зэрэг үр ашигтай шийдвэрлэж байгааг харуулдаг, аливаа үйлдвэрлэл, үйл ажиллагаанд зарцуулах бүх төрлийн орцын ашиглалтын түвшинг илэрхийлдэг эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүд юм. Эдийн засгийн шалгуур үзүүлэлт болох хэмнэлт, үр ашиг нь эцсийн дүнд бүтээмжээр дамжин илэрдэг.

Бүтээгдэхүүнийг бүтээн бий болгоход зарцуулж байгаа нөөцийг хамгийн боломжит хэмжээгээр багасгаж, энэхүү нөөцийг ашигласны дүнд бүтээгдэн бий болж байгаа гарцын хэмжээг дээд зэргээр нэмэгдүүлснээр бүтээмж өснө. Бүтээмжийн өсөлт нь хүн ардын амьжиргааны түвшин, инфляцид эерэгээр нөлөөлдөг.

3. Бүтээмжийн төрлүүд, түүнийг тооцох арга

Бүтээмж нь үйлдвэрлэлийн дүнд бий болсон нийт гарц, энэхүү үйлдвэрлэлийг явуулахад оруулсан орцын харьцаагаар, дараахь байдлаар илэрхийлэгдэнэ.

$$\text{Бүтээмж} = \frac{\text{Гарц}}{\text{Орц}}$$

Дээрх томъёоллоос гарц, орц гэсэн 2 үзүүлэлтийг тооцох шаардлагатай болно.

Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон “гарц”-ын үзүүлэлтээр:

- Үйл ажиллагааны нийт орлого буюу борлуулалтын орлого
- Үйлдвэрлэлийн хэмжээ (өртгөөр)
- Нэмэгдэл өртөг

- Нийт ашиг
- Цэвэр ашиг зэргийг авч хэрэглэж болно.

Дээрх үзүүлэлтүүдээс шинжилгээ, судалгааны ажил хийхэд хамгийн оновчтой гэж үздэг, түгээмэл хэрэглэгддэг үзүүлэлт нь тухайн тайлант хугацаанд эдийн засагт шинээр бий болсон бүтээгдэхүүн буюу **нэмэгдэл өртөг** юм. Энэхүү аргачлалд нэмэгдэл өртгийг гарцын үзүүлэлт болгож авна.

Нийт эдийн засгийн хувьд тооцсон нэмэгдэл өртгийн нийлбэрүүдийг Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) гэж нэрлэдэг. ДНБ-ийг **үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын** гэсэн 3 аргаар тооцно. Эдгээрээс бүтээмж тооцоход хамгийн тохиромжтой нь үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэмэгдэл өртөг буюу ДНБ болно.

“Орц” гэдэг нь аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад зарцуулсан бүх зардлууд (цалин, үндсэн хөрөнгийн элэгдэл, түүхий эд, үндсэн материал, эрчим хүч, дулаан, бичиг хэрэг г.м) юм.

Бүтээмжийг дотор нь *нийт бүтээмж, үндсэн хүчин зүйлсийн бүтээмж, тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмж* гэсэн 3 хэлбэрээр, түүнчлэн нийт эдийн засгийн хувьд, салбар, дэд салбар, сектор, аж ахуйн нэгжийн хувьд тооцож болно.

Бүтээмжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар тооцох ерөнхий зарчим ижил юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үйл ажиллагааны дараахь салбарууд: хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэр, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар, үйлчилгээ, зочид буудал, зоогийн газар, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, санхүүгийн гүйлгээ, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагааны хувьд тооцооны зарчим ижил байна гэсэн үг.

Одоо бүтээмжийн дээрх 3 хэлбэрээр хэрхэн тооцох талаар авч үзье.

Нийт бүтээмж

Нийт бүтээмж нь бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд зарцуулсан нийт зардлын нэг төгрөг тутмаас хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн бий болгож чадсаныг харуулдаг үзүүлэлт бөгөөд дараахь байдлаар илэрхийлэгдэнэ. Үүнд:

$$\text{Нийт бүтээмж} = \frac{\text{ДНБ (нэмэгдэл өртөг)}}{\text{Цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод) + үндсэн хөрөнгийн элэгдэл+завсрын хэрэглээ}}$$

Нийт бүтээмжийг улсын болон салбаруудын түвшинд тооцож болно.

а) Улсын түвшинд

Нийт бүтээмжийг улсын түвшинд тооцоходоо оны үнээр тооцсон ДНБ-ийг энэхүү ДНБ-ийг бий болгоход зарцуулсан цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдэл, шууд бус татвар, завсрын хэрэглээний нийлбэрт хувааж тооцно. Газар, байгалийн нөөц ашигласны төлбөр шууд бус татварт хамаарахгүй. *Мэдээллийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Энэхүү нэгтгэлд дээр дурьдсан ДНБ, түүнийг бий болгоход зарцуулсан нийт зардлууд болох цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдэл, шууд бус татвар, завсрын хэрэглээны зардлууд тусгагдсан байдаг.*

б) Салбарын түвшинд

Нийт бүтээмжийг салбаруудын түвшинд тооцох ерөнхий зарчим улсын түвшинд тооцож байгаатай адил бөгөөд салбар болгоны хувьд бий болсон нэмэгдэл өртгийг тухайн нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан нийт зардал болох цалин(эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдэл, шууд бус татварууд, завсрын хэрэглээний нийлбэрт хувааж тооцно. *Мэдээллийн эх үүсвэр нь салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо бөгөөд энэхүү нэмэгдэл өртгийн бий*

болгоход зарцуулсан цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдэл, шууд бус татвар, завсрын хэрэглээний зардлууд байна.

3.2. Үндсэн хүчин зүйлсийн бүтээмж

Үндсэн хүчин зүйлийн бүтээмж нь үйлдвэрлэлийн гол хүчин зүйлс болох хөдөлмөр, капиталын ашиглалтын үр ашгийг тодорхойлж, тэдгээрийн хоорондох оновчтой хослолыг харуулах ба шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийн нөлөөллийн үр дүнг тусган илэрхийлдэг үзүүлэлт юм.

$$\text{Үндсэн хүчин зүйлсийн бүтээмж} = \frac{\text{ДНБ (нэмэгдэл өртөг)}}{\text{(цалин + үндсэн хөрөнгийн элэгдэл)}}$$

а) Улсын түвшинд

Үндсэн хүчин зүйлийг улсын түвшинд тооцохдоо оны үнээр тооцсон ДНБ-ийг энэхүү ДНБ-ийг бий болгоход зарцуулсан цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдлийн нийлбэрт хувааж тооцно. *Мэдээллийн эх үүсвэр нь* үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Энэхүү нэгтгэлд дээр дурьдсан ДНБ, түүнийг бий болгоход зарцуулсан цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлууд тусгагдсан байдаг.

б) Салбарын түвшинд

Нийт бүтээмжийг салбаруудын түвшинд тооцох ерөнхий зарчим улсын түвшинд тооцож байгаатай адил бөгөөд салбар болгоны хувьд бий болсон нэмэгдэл өртөг(оны үнээр тооцсон)-ийг тухайн нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан нийт зардал болох цалин(эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдлийн нийлбэрт хувааж тооцно. *Мэдээллийн эх үүсвэр нь* салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо бөгөөд энэхүү нэмэгдэл өртгийг бий болгоход

зарцуулсан цалин (эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл ороод), үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлууд байна.

3.3. Тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмж

Тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмжийг улсын түвшинд тооцохоос гадна салбар, сектор, аж ахуйн нэгжийн түвшинд тооцож болох бөгөөд зардлын төрөл тус бүрээр, тухайлбал хөдөлмөр, капитал, материал, эрчим хүчний бүтээмж байдлаар тооцож болно. Энэхүү үзүүлэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд зарцуулсан зардлын нэг төгрөг тутмаас хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн бий болгож чадсаныг харуулдаг үзүүлэлт юм.

3.3.1 Хөдөлмөрийн бүтээмж

Хөдөлмөр нь аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад зайлшгүй шаардлагатай хамгийн чухал, бодитой хэмжигдэхүйц хүчин зүйл. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо нэмэгдэл өртөг (ДНБ)-ийн хэмжээг хөдөлмөрт хуваана.

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж} = \frac{\text{ДНБ (нэмэгдэл өртөг)}}{\text{Хөдөлмөр}}$$

Хөдөлмөрийн үзүүлэлтийг хэд хэдэн үзүүлэлтээр авч болно. Хөдөлмөрийн бүтээмж нь хөдөлмөрийг ямар хэлбэрээр авч байгаагаас хамаарч дараахь төрлүүдтэй байна. Тухайлбал: нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмж, нэг цагт ногдох хөдөлмөрийн бүтээмж (ажилласан хүн цагаар хэмжигдэнэ), нэг өдөрт ногдох хөдөлмөрийн бүтээмж (ажилласан хүн өдрөөр хэмжигдэнэ), хөдөлмөрийн хөлсний нэгж тутамд ногдох хөдөлмөрийн бүтээмж. Эдгээрийг тус бүрд нь авч үзье.

Нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмж

а) Улсын түвшинд

Нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо тухайн жилд бий болсон ДНБ (оны үнээр тооцсон)-ийг тухайн жилд ажилласан жилийн дундаж ажиллагчдын тоонд хуваана. Жилийн дундаж ажиллагчдыг тооцохдоо оны эхэнд болон эцэст байгаа ажиллагчдын тооны нийлбэрийг хоёрт хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл, ажиллах хүчний статистикаар нэгтгэгдэн гардаг ажиллагчдын тоо байна.*

б) Салбарын түвшинд

Нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмжийг салбарын түвшинд тооцох тооцоо нь зарчмын хувьд улсын түвшинд тооцож байгаатай ижил байна. Тухайн салбарын нэмэгдэл өртөг (оны үнээр тооцсон)-ийг нэмэгдэл өртгийг бий болгосон тухайн салбарын ажиллагчдын жилийн дундаж тоонд хуваана. Жилийн дундаж ажиллагчдыг тооцохдоо оны эхэнд болон эцэст байгаа ажиллагчдын тооны нийлэрийг хоёрт хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо, ажиллах хүчний статистикаар салбаруудаар нэгтгэгдэн гардаг ажиллагчдын тоо юм.*

Нэг цагийн хөдөлмөрийн бүтээмж

а) Улсын түвшинд

Нэг цаг ажиллахад ногдох хөдөлмөрийн бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо тухайн жил бий болсон ДНБ (оны үнээр тооцсон)-ийг тухайн жилд ажилласан жилийн дундаж ажиллагчдын нийт ажилласан цагт хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Мэдээллийн эх үүсвэрээс шалтгаалж нэг цагийн бүтээмжийг одоогоор тооцох боломжгүй байна. **Иймд ажиллагчдын жилийн дундаж ажилласан цагийн статистик мэдээллийг цаашид бий болгох шаардлагатай.***

б) Салбарын түвшинд

Нэг цаг ажиллахад ногдох хөдөлмөрийн бүтээмжийг салбарын түвшинд тооцох тооцоо нь зарчмын хувьд улсын түвшинд тооцож байгаатай ижил, салбарын

нэмэгдэл өртөг (оны үнээр тооцсон)-ийг тухайн салбарт, тухайн жилд ажилласан жилийн дундаж ажиллагчдын ажилласан цагт хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо юм. Мэдээллийн эх үүсвэрээс шалтгаалж нэг цагийн бүтээмжийг салбараар тооцох боломжгүй байна. **Иймд ажиллагчдын жилийн дундаж ажилласан цагийн статистик мэдээллийг цаашид салбараар бий болгох шаардлагатай.***

Нэг өдрийн хөдөлмөрийн бүтээмж

а) Улсын түвшинд

Нэг өдрийн хөдөлмөрийн бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо тухайн жилд бий болсон ДНБ (оны үнээр тооцсон)-ийг тухайн жилд ажилласан жилийн дундаж ажиллагчдын нийт ажилласан өдөрт хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Мэдээллийн эх үүсвэрээс шалтгаалж нэг өдрийн бүтээмжийг тооцох боломжгүй байна. **Иймд ажиллагчдын хүн өдрийн статистик мэдээллийг цаашид бий болгох шаардлагатай.***

б) Салбарын түвшинд

Нэг өдрийн хөдөлмөрийн бүтээмжийг салбарын түвшинд тооцох тооцоо нь улсын түвшинд тооцож байгаатай зарчмын хувьд ижил байна. Салбарын түвшинд тооцохдоо тухайн салбарын нэмэгдэл өртөг (оны үнээр тооцсон)-ийг тухайн салбарт, тухайн жилд ажилласан жилийн дундаж ажиллагчдын ажилласан өдөрт хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо юм. **Ажиллагчдын хүн өдрийн статистик мэдээллийг цаашид салбараар бий болгох шаардлагатай.***

Хөдөлмөрийн хөлсний нэгж тутамд ногдох хөдөлмөрийн бүтээмж.

а) Улсын түвшинд

Хөдөлмөрийн хөлсний нэгж тутамд ногдох хөдөлмөрийн бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо тухайн жил бий болсон ДНБ(оны үнээр тооцсон)-ийг тухайн жилд ажилласан жилийн дундаж ажиллагчидад олгосон цалингийн нийт хэмжээнд хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь* үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Энэхүү нэгтгэлээс оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ, ДНБ-ий бүрэлдэхүүнд багтдаг цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн нийт хэмжээг авч тооцно.

б) Салбарын түвшинд

Хөдөлмөрийн хөлсний нэгж тутамд ногдох хөдөлмөрийн бүтээмжийг салбарын түвшинд тооцох тооцоо нь зарчмын хувьд улсын түвшинд тооцож байгаатай ижил байна. Тухайн салбарын нэмэгдэл өртөг (оны үнээр тооцсон)-ийг тухайн салбарын ажиллагчдад олгосон хөдөлмөрийн хөлс буюу цалингийн хэмжээнд хувааж тооцно. *Мэдээллийн эх үүсвэр нь* салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо, нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүнд багтдаг цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн нийлбэр байна.

3.3.2 Капиталын бүтээмж

Үйлдвэрлэлд ашигласан нэгж капиталаар бүтээгдсэн зүйлийн үнэ цэнийг капиталын бүтээмж харуулна. Капиталын бүтээмжийг дараахь байдлаар тооцно.

$$\text{Капиталын бүтээмж} = \frac{\text{ДНБ(нэмэгдэл өртөг)}}{\text{үндсэн хөрөнгийн элэгдэл}}$$

а) Улсын түвшинд

Капиталын бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо ДНБ-ий гүйцэтгэлийг түүнд зарцуулсан капиталын хэмжээнд буюу үндсэн хөрөнгийн элэгдэлд харьцуулж тооцно. Капиталын бүтээмжийг үйлдвэрлэлийг явуулах үед байсан капиталын нийт өртгийн хэмжээнд харьцуулж тооцож болох боловч тухайн үйлдвэрлэлд зарцуулсан капиталын зардал гэдэг утгаараа *хөрөнгийн элэгдэл нь* илүү тохиромжтой гэж үздэг. *Мэдээллийн эх үүсвэр нь* үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Уг нэгтгэлээс оны үнээр тооцсон ДНБ-

ий хэмжээ, ДНБ-ий бүрэлдэхүүнд багтдаг үндсэн хөрөнгийн элэгдлийн нийт хэмжээг авна.

б) Салбарын түвшинд

Капиталын бүтээмжийг салбаруудын түвшинд тооцохдоо тухайн салбарын нэмэгдэл өртгийг энэхүү нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан тухайн салбарын капиталын хэмжээнд буюу үндсэн хөрөнгийн элэгдэлд харьцуулж тооцно. *Мэдээллийн эх үүсвэр нь* салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо, энэхүү нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүнд багтдаг үндсэн хөрөнгийн элэгдэл байна.

3.3.3 Түүхий эд, үндсэн материалын бүтээмж

Түүхий эд, үндсэн материалын бүтээмж нь үйлдвэрлэлд зарцуулсан үндсэн түүхий эд материалын үр ашгийг харуулдаг үзүүлэлт бөгөөд дараахь байдлаар тооцогдоно.

$$\text{Түүхий эд, үндсэн материалын бүтээмж} = \frac{\text{ДНБ(нэмэгдэл өртөг)}}{\text{түүхий эд, үндсэн материалын зардал}}$$

а) Улсын түвшинд

Түүхий эд, үндсэн материалын бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо ДНБ-ийг түүхий эд, үндсэн материалын нийт зардалд хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь* үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Уг нэгтгэлээс оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ, завсрын хэрэглээний бүрэлдэхүүнд багтдаг түүхий эд, үндсэн материалын зардлын нийт хэмжээг авна.

б) Салбарын түвшинд

Түүхий эд, үндсэн материалын бүтээмжийг салбаруудын түвшинд тооцохдоо тухайн салбарын нэмэгдэл өртгийг энэхүү нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан түүхий эд, үндсэн материалын зардалд хуваана. *Мэдээллийн эх үүсвэр*

нь салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо, энэхүү нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан түүхий эд, үндсэн материалын зардлын хэмжээ байна.

3.3.4 Эрчим хүчний бүтээмж

Эрчим хүч нь үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах чухал нөөц бөгөөд түүний үр ашигтай, зохистой хэрэглээг эрчим хүчний бүтээмжийн үзүүлэлт илэрхийлдэг.

$$\text{Эрчим хүчний бүтээмж} = \frac{\text{ДНБ(нэмэгдэл өртөг)}}{\text{Эрчим хүчний зардал}}$$

а) Улсын түвшинд

Эрчим хүчний бүтээмжийг улсын түвшинд тооцохдоо ДНБ-ийг эрчим хүчний нийт зардалд хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий тооцооны нэгтгэл юм. Энэхүү нэгтгэлээс оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ, завсрын хэрэглээний бүрэлдэхүүнд багтдаг эрчим хүчний зардлын нийт хэмжээг авна.*

б) Салбарын түвшинд

Эрчим хүчний бүтээмжийг салбаруудын түвшинд тооцох тооцооны зарчим нь улсын түвшинд тооцож байсантай ижил. Тухайн салбарын нэмэгдэл өртгийг энэхүү нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан салбаруудын эрчим хүчний зардалд хуваана. *Мэдээллийн эх үүсвэр нь салбар бүрийн хувьд тооцдог нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн оны үнийн тооцоо, энэхүү нэмэгдэл өртгийн бий болгоход зарцуулсан эрчим хүчний зардал байна.*

Жишээ болгон аж үйлдвэр, хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдааны салбарын бүтээмжийн тооцоог хийж хавсаргав.